

Сангийн сайдын 2013 оны 05
дугаар сарын 31-ний өдрийн 125
дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.
ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирх үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

[ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР]

Огноо: **2020.09.16**

**[ТӨВ АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ “ӨВС”] ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер
шалгаруулалт / ТӨАОНӨГ/202007098
гэрээний дугаар:**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.09.16

[Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар] нь эрх бүхий тендерт оролцогчдоос [Төв аймгийн Аюулгүйн нөөцөд “өөс” нийлүүлэх ажил]-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэх цахим тендерт урьж байна.

Тендерийн баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААНЭГЖИЙН хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.

Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb, байна.

Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж 0,00 /тэг/ төгрөгийг (www.tender.gov.mn)-ээр банкны Е-Меркантийн системийг ашиглан төлнө. Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт бүхий ажлын зураг болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 11 цаг 00 минут-аас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn хаягаар ирүүлсэн байна.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан цахим системээр **2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 11 цаг 10 минут-д** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. “**Тооцно**”.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Төв аймаг,
Орон нутгийн өмчийн газар,
Төр, Захиргааны 2 дугаар байр,
Утас: 7027-3579, 9930-9495
Төрийн Худалдан Авах Ажиллагааны Цахим Систем
www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

хүчинтэй байх хугацаа

- | | |
|--|---|
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-đ заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Сүүлийн [2017, 2018, 2019 оны] аль нэг жилд нь туршлагын мэдээлэл /ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, ажил хүлээлгэж өгсөн комиссын акт/;</p> <p>2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;</p> <p>3. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх буюу татварын ерөнхий газрын www.e.tax.mta.mn сайтыг ашиглан цахим бар код бүхий тодорхойлолтыг ирүүлнэ;</p> <p>4. <u>Компаний</u> сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийг <u>Шүүхийн төрөлжсөн архивын</u> тодорхойлолтыг ирүүлнэ;</p> <p>5. <u>Компаний</u> сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийн <u>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын</u> тодорхойлолтыг ирүүлнэ;</p> <p>6. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягт №ТШМ-2-2 дагуу гаргаж баталгаажуулж ирүүлнэ;</p> <p>7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, банк болон дээрх холбогдох байгууллагаас тендерийн баримт бичигтэй холбоотой асуудлаар нэмэлт тодорхойлолт, лавлагаа гаргуулахад тендерт оролцогч татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг ирүүлнэ;</p> <p>8. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлнэ;</p> <p>9. Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ;</p> <p>10. Тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг, үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзахгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдлийг гаргаж ирүүлнэ;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <p>Байвал зохих ажилтан.</p> <p>1. Өвс, хадагч, хаман боогч -2 /энэ чиглэлээрээ 2-аас доошгүй жил ажилласан байх туршлагатай/</p> <p>2. Тээвэрлэгч буюу жолооч -2 /2-оос доошгүй жил тээврийн жолоочоор ажилласан байх туршлагатай/</p>

	<p>Ажилчдын иргэний үнэмлэх, болон мэргэжлийн /жолооны/ үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ,</p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлагах шаардлагатай</p> <p>1. Тендерт оролцогч нь уг ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санал болгож <u>тээврийн хэрэгслийн техникийн гэрчилгээг</u> ирүүлнэ;</p> <p>ТШӨХ-н ТОӨЗ-ны 1.1-т заасан тодорхойлолт, мэдэгдлүүд нь тендер зарласан өдрөөс хойш авсан, гаргасан байх бөгөөд өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй эсхүл дээр заасан тодорхойлолтууд, баримт бичгүүдээс ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах болохыг анхаарна уу.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Төв аймаг, Орон нутгийн өмчийн газар, Төр захиргааны 2 дугаар байр</p> <p>Огноо: [2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр]</p> <p>Цаг: [11 цаг 00 минут]</p> <p>Энэхүү тендер нь цахим тендер тул тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.</p> <p>Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалыа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Тендер нь Цахим Тендер Шалгаруулах Журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим Худалдан Авх Ажиллагааны Систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн нэвтрэх үг, нууц дугаараар нэвтрэн орж тоон гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр материалыа ирүүлнэ үү.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Үнийн саналын нээлтийг www.tender.gov.mn цахим системээр [2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 11 цаг 10 минут-д нээнэ.</p>
ТОӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <p>11. Сүүлийн [2017, 2018, 2019 оны] аль нэг жилд нь</p>

	<p>туршлагын мэдээлэл /ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, ажил хүлээлгэж өгсөн комиссын акт/;</p> <p>12. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;</p> <p>13. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх буюу татварын ерөнхий газрын www.e.tax.mta.mn сайтыг ашиглан цахим бар код бүхий тодорхойлолтыг ирүүлнэ;</p> <p>14. <u>Компаний</u> сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцгчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийг <u>Шүүхийн төрөлжсөн архивын</u> тодорхойлолтыг ирүүлнэ;</p> <p>15. <u>Компаний</u> сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцгчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийн <u>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаын</u> тодорхойлолтыг ирүүлнэ;</p> <p>16. Тендерт оролцгчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягт №ТШМ-2-2 дагуу гаргаж баталгаажуулж ирүүлнэ;</p> <p>17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, банк болон дээрх холбогдох байгууллагаас тендерийн баримт бичигтэй холбоотой асуудлаар нэмэлт тодорхойлолт, лавлагаа гаргуулахад тендерт оролцогч татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг ирүүлнэ;</p> <p>18. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлнэ;</p> <p>19. Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ;</p> <p>20. Тендерт оролцгчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг, үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзахгүй тухай тендерт оролцгчийн албан мэдэгдлийг гаргаж ирүүлнэ;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <p>Байвал зохих ажилтан.</p> <ol style="list-style-type: none"> 3. Өвс, хадагч, хаман боогч -2 /энэ чиглэлээрээ 2-аас доошгүй жил ажилласан байх туршлагатай/ 4. Тээвэрлэгч буюу жолооч -2 /2-оос доошгүй жил тээврийн жолоочоор ажилласан байх туршлагатай/ <p>Ажилчдын иргэний үнэмлэх, болон мэргэжлийн /жолооны/ үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ,</p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай</p> <ol style="list-style-type: none"> 2. Тендерт оролцогч нь уг ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санал
--	--

	болгож <u>тээврийн хэрэгслийн техникийн гэрчилгээг ирүүлнэ;</u>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [Багцгүй] ТӨАОНӨГ/202007098

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Барааны тодорхойлолт: [Гүйцэтгэгч нь аймгийн аюулгүйн иөөцөд өвс нийлүүлнэ.]
- Стандарт: Гүйцэтгэгчийн нийлүүлсэн бүтээгдэхүүн 2020 онд бэлдсэн, MNS 0592:2008 стандартын шаардлага хангасан байна.

3. Баглаа, боодол:

Нэг боодол өвсний хэмжээ: 50*30*80 см

Нэг боодол өвсний нягтрал: 120-130 кг/м³

Өнгө: хар ногоон, цайвар ногоон

Үнэр: Өвсний өмөрмөц анхилам үнэртэй

Чийг: 15 хувиас ихгүй байна.

- Бараа хүргэх газар: Төв аймгийн Зуунмод сум Зүүндэлгэр багт байрлах Махны үйлдвэрийн хашаанд гүйцэтгэгч өөрийн унаагаар хүргэж ирэх бөгөөд өвсийг стандартын шаардлага хангаж өрж нуруулдан өгнө.

5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Төдорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан бараг хүргэх эсийн цэг	Инкотермиийн нөхцлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Багц 1	Аймгийн аюулгүйн иөөц	137 тн 6857 боодол	тн	Төв аймаг Зуунмод сум Зүүндэлгэр 4-р баг	2020 оны 10 сарын 01	2020 оны 10 сарын 15	

Төсөвт өртөг: 48.000.000 /Дөчин найман сая төгрөг/

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойл олт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэг ж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа КС	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хугаарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хугаарьг мөрднө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д |

заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

- | | |
|---|---|
| 10.Үүргээ
биелүүлээг
үй-гээс
гэрээг
цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11.Маргааныг
шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Захиалагчийн төлөөлөгч өвсний чанар, жин, баглаа боодол болон бусад техникийн тодорхойлолтод заасан нөхцөлөөр зохих шаардлагын дагуу шалгалт, туршилтыг нийлүүлэгдэх бараа бүрт зохион явуулна. Нийлүүлэгч нь өнжмөл бус 2020 онд хадсан шинэ өвч нийлүүлнэ.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> | |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Нийлүүлэгчээс техникийн тодорхойлолтод заасан нөхцөл, шаардлагын дагуу нийлүүлээгүй, нийлүүлсэн бараа нь захиалагчийн шаардсан нөхцөлийг хангахгүй тохиолдолд нийлүүлэгч нь засварлаж, сольж өгнө.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн [100]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² | 9.1. Алданги оногдуулах хувь: [0.05 хувь]

Алдангийн нийт дүн: [10 хувь] |

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____-наас _____ оны ____ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.